

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал  
/2018 оны 12 дугаар сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO<sub>2</sub>), азотын давхар исэл (NO<sub>2</sub>), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O<sub>3</sub>) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар болон химийн аргаар тодорхойлж байна.

2018 оны хүйтний улирлын 12 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 18 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 8%-аар, хүхэрлэг хий 12 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 28%-аар тус тус их байсан бол PM2.5 тоосонцор 15 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 8%-аар, азотын давхар исэл 10 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 16%-аар бага байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м <sup>3</sup>	
	Хүлцэх агууламж, мкг/м <sup>3</sup>	2017 оны 12-р сар	2018 оны 12-р сар
PM10 тоосонцор	100	224	242↑
Хүхэрлэг хий, SO <sub>2</sub>	50	42	54↑
PM2.5 тоосонцор	50	197	182↓
Азотын давхар исэл, NO <sub>2</sub>	50	61	51↓

Улаанбаатар хотын сүүлийн 4 жилийн хүйтний улирал дахь гол бохирдуулах бодис тус бүрийн сарын дундаж агууламжийг дараах хэсэгт харуулав.


**PM10 тоосонцор**



Зураг 1. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2015-2018 он

Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын 2018 оны 12 дугаар сарын дундаж агууламжийг 2017 оны мөн үетэй харьцуулахад 18 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 8%-иар их, Агаарын чанарын стандарт дахь Хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-тай харьцуулахад 2.4 дахин их байна (Зураг 1).


### PM2.5 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2015-2018 он

Агаар дахь PM2.5 тоосонцрын 2018 оны 12 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 8%-иар бага, АЧС дахь ХА-аас 3.6 дахин их байна (Зураг 2).


### Хүхэрлэг хий (SO<sub>2</sub>)



Зураг 3. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2015-2018 он

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн 2018 оны 12 дугаар сарын дундаж агууламжийг 2017 оны мөн үетэй харьцуулахад 12 мкг/м<sup>3</sup>-ээр буюу 28%-аар их, АЧС дахь ХА-аас 1.1 дахин их байна (Зураг 3).

### Азотын давхар исэл ( $NO_2$ )



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2015-2018 он

Агаар дахь азотын давхар ислийн 2018 оны 12 дугаар сарын дундаж агууламжийг 2017 оны мөн үетэй харьцуулахад  $10 \text{ mcg/m}^3$ -ээр буюу 16%-аар бага, АЧС дахь ХА-ийн түвшинд байна (Зураг 4).

ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО

**АЖЛЫН АЛБА**